



МОНГОЛ УЛС
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА

Жанжин Д. Сүхбаатарын талбай 7, 1 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0035
Утас: 32-71-99, Факс: (976-11) 32-21-47
<http://www.ulaanbaatar.mn>

2020. 11. 03 № 02-02/0219
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН
ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДАД

Улсын Онцгой комиссын 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 04 дүгээр албан даалгавар, Нийслэлийн Онцгой комиссын 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 14 дүгээр хурлын тэмдэглэлээр үүрэг болгосон “Маскаа зүүцгээе, гараа угаа” 2 дугаар аяны хэрэгжилтийг ханган ажиллаж, ажлын тайлан мэдээг Нийслэлийн Эрүүл мэндийн газарт долоо хоног бүрийн “Пүрэв” гарагт ирүүлнэ үү.

Холбогдох материалыг хавсаргав.

Хавсралт 5 хуудастай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
БОДЛОГЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН
ОРЛОГЧ **Н.БАЯРЧИМЭГ**





УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
АЛБАН ДААЛГАВАР

2020 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

「КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН
ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
АЖЛЫН ХҮРЭЭНД "МАСКАА ЗҮҮЦГЭЭЕ,
ГАРАА УГААЯ" 2 ДУГААР АЯНЫГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 28 дугаар зүйл, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6 дахь заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга нар, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Харилцаа холбооны зохицуулах хороонд тус тус ДААЛГАХ НЬ:

Нэг. Мэдээлэл сурталчилгааг эрчимжүүлэх.

1.1 Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд "Маскаа зүүе, гараа угаая" аяныг хэвлэл мэдээллийн байгууллагууд (телевиз, радио, сонин, төрөл бүрийн цахим хуудас, багц мессеж)-аар сурталчилж ажиллах;

1.2 Уг аяны хүрээнд хэвлэмэл хуудас, гарын авлагуудыг төрийн болон төрийн бус байгууллагуудаар дамжуулан иргэдэд хүргэх;

Хоёр. Яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга нар төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах;

2.1 Тус аянд яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга нар харьяа байгууллагуудаа идэвхтэй хамруулах;


2.2 Аймаг, нийслэлийн Засаг дарга нар төв, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажиллах;

Гурав. Аяныг 2020 оны 10 дугаар сарын 05-ны өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал;

Дөрөв. Албан даалгаврын хэрэгжилтийг тайлагнах.

Аймаг, нийслэлийн хүрээнд албан даалгаврын биелэлтэд хяналт тавьж, мэдээ тайланг нэгтгэн Улсын Онцгой комиссын Шуурхай штабт 7 хоног бүрийн Баасан гарагт цахимаар болон албан бичгээр ирүүлэх.

ДАРГА,
ШАДАР САЙД



Я.СОДБААТАР



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 10 сарын 27 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Нийслэлийн Онцгой комиссын 14 дүгээр хурал 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 17:00 цагт Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хурлын "А" танхимд гишүүдийн 91.4 хувийн ирцтэй хуралдав.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Коронавируст /Ковид-19/ цар тахлын нөхцөл байдал,
2. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 62, 2020 оны 189 дүгээр тогтоолын хүрээнд түүхий нүүрсний хэрэглээнд тавигдаж байгаа хяналт шалгалтын талаар тус тус хэлэлцэв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар,
Нутгийн Захиргааны байгууллагууд,
Дүүргийн Онцгой комиссын дарга нарт

1.1. Улсын онцгой комиссын 2020 оны Коронавируст /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд "Маскаа зүүцгээе, гараа угаая" 2 дугаар аяныг зохион байгуулах тухай 04 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангуулан нийслэл, дүүргийн хэмжээнд 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд аян зохион байгуулж, иргэн, аж ахуй нэгж байгууллагуудыг аянд нэгтгэх, өөрсдийгөө эрсдэлээс хамгаалах чиглэлээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн хүрээнд сэрэмжлүүлэг өгч ажиллах.

1.2. Нутгийн захиргааны нийт байгууллагууд ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж, халдвар хамгааллын дэглэмийг сахиулах, маскаа тогтмол зүүж хэвших, маскгүй иргэнд үйлчлэхгүй байх шаардлагыг тавьж Коронавируст /Ковид-19/ цар тахал, ханиад томуунаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллах.

1.3. Аяны хүрээнд зохион байгуулсан ажлын дүн мэдээг долоо хоног бүрийн Пүрэв гарагийн 15:00 цагт Нийслэлийн Эрүүл мэндийн газрын ubhealth2020@gmail.com цахим хаягт ирүүлж байх.

Хоёр. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар,
Нийслэлийн Онцгой байдлын газарт

2.1. Коронавируст /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлж "Маскаа зүүцгээе, гараа угаая" аяныг Нийслэл, дүүргийн хэмжээнд зохион байгуулж байгаа ажилд явцын хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулан, аяны дүн мэдээг долоо хоног бүрийн Баасан гарагт Улсын Онцгой комиссын шуурхай штабт хүргүүлж байх.

Гурав. Нийслэлийн Зам, тээврийн асуудал хариуцсан
төслүүдийн удирдагч,
Нийслэлийн Нийтийн тээврийн үйлчилгээний газарт

3.1. Нийтийн тээврийн хэрэгслийн дотор, гадна ариутгал, халдваргүйтгэлийг тогтмол хийлгэх, ариутгалын бодис байрлуулан иргэдийг гараа ариутгах нөхцөлөөр хангах.

3.2. Нийтийн тээврийн үйлчилгээнд амны хаалт зүүгээгүй иргэдэд үйлчлэхгүй байх шаардлага тавьж, иргэдэд Коронавируст /Ковид-19/ цар тахал, томуу, томуу тест өвчнөөс өөрийгөө болон бусдыг хамгаалах талаар зөвлөмж мэдээлэл хүргэх.

Дөрөв. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба,
Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар,
Нийслэлийн Цагдаагийн удирдах газар,
Нийслэлийн Боловсролын газар,
Нийслэлийн Соёл урлагийн газар,
Нийслэлийн Биеийн тамир спортын хороо,
Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт

4.1. Боловсрол, соёл урлаг, үзвэр үйлчилгээ, олон нийтийг хамарсан арга хэмжээ, зах худалдаа үйлчилгээний байгууллагуудад ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийлгэж, халдвар хамгааллын дэглэмийг сахиулах, иргэн, аж ахуй нэгж байгууллагууд нийгмийн хариуцлагын хүрээнд "Маскаа зүүцгээе, гараа угаая" аяныг зохион байгуулж, маскаа тогтмол зүүж хэвших, маскгүй иргэнд үйлчлэхгүй байх шаардлагыг тавьж, албан даалгаврын хэрэгжилтийг хангуулж хяналт тавих.

Тав. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба,
Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар,
Нийслэлийн Цагдаагийн удирдах газарт

5.1. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоолд орсон өөрчлөлтийн дагуу түүхий нүүрс түлэхийг хориглосон Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо, Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо, Хан-Уул дүүргийн 12, 13, 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт оршин суудаг айл өрх, үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын түүхий нүүрсний хэрэглээнд хяналт тавьж, өнжмөл түүхий нүүрсийг худалдан авах ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах.

5.2. Түүхий нүүрсийг Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоодоор болон маршрутын бус замаар нийслэлийн нутаг дэвсгэрт нэвтрүүлэхгүй байхад онцгой анхаарч хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулах, зөвшөөрөлтэй аж ахуй нэгжүүдийн түүхийн нүүрсний хэрэглээг бүрэн хяналтад оруулах.

5.3. Түүхий нүүрс түлж агаар, орчны бохирдол үүсгэж байгаа тохиолдлуудыг илрүүлэх чиглэлээр хөдөлгөөнт хяналт, шалгалт зохион байгуулж ажиллах.

Зургаа. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар,
Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс,
Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газарт

6.1. Сайжруулсан шахмал түлшийг цэгүүдэд тээвэрлэх, тээврийн компаниудтай гэрээг яаралтай байгуулж, түлшний тээвэрлэлтийн үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулах нөхцөлийг бүрдүүлэх.

Долоо. Нийслэлийн Агаар орчны бохирдлын асуудал
хариуцсан төслүүдийн удирдагч,
Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар,
Дуургүүдийн Онцгой комиссын дарга,
Таван толгой түлш ХХК-д

7.1. Иргэн аж ахуйн нэгж байгууллагуудын сайжруулсан шахмал түлшний зөв хэрэглээ, пийшин зуухны галлагааны аюулгүй байдлыг хангаж, угаарын хий мэдрэгч төхөөрөмжийг зөв ашиглаж, угаартах эрсдэлээс сэргийлэх, зөвлөмж зөвлөгөөг эрсдэл бүхий айл өрхүүдэд тогтмол хүргэж сэрэмжлүүлэн ажиллах.

7.2. Сайжруулсан шахмал түлшний нөөц, түлш борлуулах цэгийн тоо, хүртээмж, байршлыг иргэдэд мэдээлж, гэрийн ойролцоох цэгээс түлшээ авч хэрэглэх нөхцөл боломжийг хангуулах ажлыг зохион байгуулах.

7.3. Гэр хорооллын 200 айл өрх хариуцсан ажилчдын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, иргэдэд угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх зөвлөмж мэдээллийг тогтмол хүргэж ажиллах.

Найм. "Таван толгой түлш" ХХК-д

8.1. Сайжруулсан түлш үйлдвэрлэх хэвийн ажиллагааг хангаж, хоногт 3000-3500 тонн түлшийг хангамжийн бааз, борлуулалтын цэгүүдэд түгээж, гэр хорооллын айл өрхийг сайжруулсан түлшээр тасралтгүй хангах.

Ес. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын
Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтэст

9.1. Коронавируст "КОВИД-19" цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд явагдаж байгаа "Маскаа зүүцгээе, гараа угаая" аян, сайжруулсан шахмал түлшний тээвэрлэлт, түгээлт борлуулалт, пийшин зуухны галлагааны аюулгүй байдал, угаарын хийн хордлогоос сэргийлэх чиглэлээр зохион байгуулж байгаа арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэдэд өргөн хүрээнд мэдээлж, сэрэмжлүүлж ажиллах.

ДАРГА



Д.СУМЬЯАБАЗАР